



ТӨР, ЗАСГИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2013 оны 09 сарын 06 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Г

Журам батлах тухай

Монгол улсын Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолын 5-дугаар хавсралт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2005 оны 15 дугаар тушаал, Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын 4.4.4 дүгээр заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын "Үйлчлэгчийн мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, мэргэшлийн ур чадварын шалгалт авах журам"ыг нэгдүгээр, "Өрөө коридорын үйлчлэгчийн ажлыг дүгнэх үзүүлэлт"-ийг хоёрдугаар, "Ариун цэврийн өрөөний үйлчлэгчийн ажлыг дүгнэх үзүүлэлт"-ийг гуравдугаар, "Өрөө, коридорын үйлчлэгчийн заавал хийж дадсан байх ажилбарыг шалгах үзүүлэлт"-ийг дөрөвдүгээр, "Ариун цэврийн өрөөний үйлчлэгчийн заавал хийж дадсан байх ажилбарыг шалгах үзүүлэлт"-ийг тавдугаар, "Өрөө, коридорын үйлчлэгчийн ажлыг дүгнэх үзүүлэлтийн хасагдах оноо"-г зургаадугаар, "Ариун цэврийн өрөөний үйлчлэгчийн ажлыг дүгнэх үзүүлэлтийн хасагдах оноо"-г долоодугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлэх ажлыг тухай бүр бэлтгэл сайтай зохион байгуулахыг Зохион байгуулалтын алба /Л.Адъяахүү/, Үйлчилгээний алба /Г.Бадам/-нд үүрэг болгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Төр, засгийн үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын даргын 2004 оны 38, 2005 оны 214 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАЛ

Д.НЯМЖАВ



13 0077

ТЗҮЭГ-ЫН ЗАХИРЛЫН 2013 ОНЫ...³⁵

ТУШААЛЫН НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ

УХЛ0194 9007699

ҮЙЛЧЛЭГЧИЙН МЭРГЭЖЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ, АХИУЛАХ, МЭРГЭШЛИЙН УР ЧАДВАРЫН ШАЛГАЛТ АВАХ, ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Тус газрын үйлчлэгчийн мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, мэргэшлийн ур чадварын шалгалт авахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, мэргэшлийн ур чадварын шалгалт нь “Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээ ерөнхий шаардлага” CS11-0060:2009 /цаашид стандарт гэнэ/ байгууллагын стандартын дагуу цэвэрлэгээ үйлчилгээний мэргэшсэн ажилтанг бэлтгэх, ажлын чанарыг дээшлүүлэх, хүний нөөцийн чадавхийг сайжруулах, цалин хөлсийг нэмэгдүүлэхэд чиглэнэ.

1.3. Шалгалтад тус газрын бүх үйлчлэгчид хамрагдана.

1.4. Жирэмсний болон хүүхэд төрүүлсний дараах амралт, чөлөөтэй болон хүндэтгэх шалтгаантай ажилтныг өөрийнх нь хүсэлтээр шалгалтад оруулах буюу чөлөөлж болно.

1.5. Сахилгын болон ёс зүйн зөрчил гаргаж тушаалаар арга хэмжээ авагдсан ажилтанг шалгалтад оруулахгүй.

1.6. Энэхүү журмыг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газар болон түүний харьяа байгууллагуудад нэгэн адил дагаж мөрдөнө.

1.7. Тус газрын дэргэдэх сургалтын төвд үйлчлэгчийн мэргэжил эзэмшсэн үйлчилгэчдийн харьяалах байгууллагын хүсэлтээр мэргэжлийн зэрэг олгох шалгалтыг зохион байгуулж болно.

Хоёр. Мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, мэргэшлийн ур чадварын шалгалтыг зохион байгуулах

2.1. Үйлчилгээний ажилтнуудад мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, мэргэшлийн ур чадварын шалгалтыг авахдаа стандартыг баримтлана.

2.2. Шалгалтыг Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын ерөнхий захирлын тушаалаар баталсан комисс зохион байгуулна.

2.3. Комиссыг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Комисс нь дарга нарийн бичгийн дарга, гишүүдээс бүрдэнэ.

2.5.Төр, засгийн үйлчилгээг эрхлэх газрын үйлчилгээ хариуцсан дэд захирал комиссын дарга, Зохион байгуулалтын албаны дарга комиссын нарийн бичгийн дарга байна.

2.4.Комисс дараах үүргийг хэрэгжүүлнэ.

2.4.1.Шалгалтын сэдэв, дадлагын ажлын төрлийг сонгож бэлтгэх, үнэлэлт дүгнэлтийг нэгтгэх, шалгалттай холбогдсон санал, гомдлыг хүлээн авч шийдвэрлэнэ.

2.4.2.Комисс дээрх шалгалтын дүнг хэлэлцэн нэгтгэж хурлын тэмдэглэл хөтөлж 2 хувь үйлдэн гарын үсэг зурж баталгаажуулна.

2.4.3.Шалгах үзүүлэлтийн хуудсанд комиссын гишүүд болон шалгалт өгсөн үйлчлэгч гарын үсэг зурсан байна.

2.4.4.Шалгалтыг 1-2 жилд нэг удаа зохион байгуулна.

**Гурав. Мэргэжлийн зэрэг олгох, ахиулах, мэргэшлийн
ур чадварын шалгалт авах**

3.1. Шалгалтыг дараах хэлбэрээр авна.

3.1.1.Шалгалт :

а/ Онолын мэдлэг /Хууль эрх зүйн болон мэргэжлийн сэдвээр / тестээр

б/ Дадлага

Дадлагын шалгалтыг өрөө, коридор, заал танхимын болон ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээ гэсэн 2 ангиллаар авна. Дадлагын шалгалтын дүнг ангилал тус бүрийн ажил, үйлчилгээнд тохирсон шалгах хуудсаар дүгнэнэ.

• Өрөө, коридор, заал танхимын үйлчлэгч 20-25 м² хэмжээтэй өрөөний өдөр тутмын цэвэрлэгээг 20-25 минутад багтаан стандартын дагуу хийж гүйцэтгэх;

• Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээг 40 минутад багтаан стандартын дагуу хийж гүйцэтгэх;

в/ Заавал хийж дадсан байх ажилбар.

Өрөө, коридор, заал танхимын үйлчлэгч нь дараах ажлуудыг заавал хийж дадсан байна. Үүнд :

- Хивс , чулуун шалыг зориулалтын машинаар угаах, цэвэрлэх, өнгөлөх;
- Мебель, ширээ болон бусад тавилгыг угааж өнгөлөх;

- Цахилгаан, электрон, /компьютер, олшруулагч, хэвлэгч, утас зэрэг/ техник хэрэгслийг угааж цэвэрлэх;

Ариун цэврийн өрөөний үйлчлэгч нь дараах ажлуудыг заавал хийж дадсан байна.

Үүнд :

- Суултуур, писаур, угаалтуур угааж цэвэрлэн өнгөлөх;
- Хананы плита, кабин, шалыг угааж цэвэрлэх;
- Холигч болон бусад никель тоноглолуудыг цэвэрлэж өнгөлөх;

3.2. Сар бүрийн ажлын үр дүнгийн үзүүлэлтийн дундаж үнэлгээ

3.3. Онолын шалгалтыг тестээр авах ба асуултыг Үйлчилгээний албатай хамтран Зохион байгуулалтын алба боловсруулна.

3.4. Дадлагын шалгалтыг Үйлчилгээний албанаас тухайн комисст орсон ажилтнууд зохион байгуулна.

Шалгалтад дараах үзүүлэлтүүдийг харгалзаж үзнэ.

- Хэрэглэгчээс гомдлын шинжтэй ноцтой дуудлага гаргасан бол -0,2
- Чанарын талонд тэмдэглэгээ хийлгэсэн бол-0,3

Дөрөв. Үнэлэлт, дүгнэлт

4.1. Шалгалтыг Онц -A/4,90-5,0/, Сайн -B/4,80-4,89/, Дунд-C/4,50-4,79/, Мүү- D /4,50 доош / гэсэн үнэлгээгээр дүгнэнэ.

4.2. Энэхүү журмын 1.3;1.4-д заасан үйлчлэгчдээс онолын болон дадлагын шалгалтыг авна. Онолын шалгалтыг тогтоосон цагт нэг зэрэг авна. Дадлага, заавал хийж сурсан байх ажилбар, сар бүрийн ажлын чанарын үнэлгээний дундачийг Үйлчилгээний алба хийнэ.

4.3. Мэргэшлийн үр чадварын шалгалтаар Онц -A/4,90-5,0/ дүнтэй шалгагдсан ажилтанд мэргэшлийн I зэрэг, Сайн -B/4,80-4,89/ дүнтэй шалгагдсан ажилтанд II зэргийн нэмэгдэл олгоно.

4.4. Шалгалтад 4,5-аас доош дүнтэй шалгагдсан ажилтанг мэргэшлийн үр чадварын хувьд тус газрын үйлчлэгчийн ажилд тэнцэх эсэхийг 3-6 сарын хугацаагаар авч үзнэ.

4.5. Шалгалтыг Монгол улсын Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны сайдын 2005 оны 15 дугаар тушаалын дагуу явуулж, Монгол улсын Засгийн газрын 1995 оны 96-р тогтоолын 5-р хавсралтын дагуу зэргийн нэмэгдэл олгох асуудлыг шалгалтын комиссын дүгнэлт, саналыг үндэслэн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

Ерее, коридорын үйлчлэгчийн ажлыг шалгах үзүүлэлт

ТҮҮГЭЗҮРҮН ЗАХИРЛЫН 2013 ОНЫ... тушаалтын хоёрдугаар хавсралт

Ажил эхэлсэн цаг, минут.....Ажил дууссан цаг , минут ..
Стандартын дагуу хийдээгүй ажлын Тэмдэглэгээ ..

Нийт хүргэлээ

Үзүүлэлтийг Онц -А/4,9-5,0/, Сайн-В /4,80-4,89/, Дунд /4,5 -4,7,79/, Мүү /4,50-аас дооши/ Үнэлгээгээр дүгнэнэ. Дутуу, огт хийгээгүй ажилбар тус бүрээс хасгдах онго /Хавсралт -3/-гоор тооцно.

Ариун цэврийн өрөөний үйлчлэгчийн ажлыг шалгах үзүүлэлт

ТҮҮХГАЗРЫН ЗАХИРЛЫН 2013 ОНЫ ТУШААЛЫН ГУРАВДУГАР ХАВСРАЛТ

Ажил эхэлсэн цаг, минут Ажил дууссан цаг , минут
Стандартын дагуу хийгдээгүй ажлын тэмдэглэгээ

Нийт хүгцаа.....

Үзүүлэлтийг Онц -А/4,9-5,0/, Сайн-В /4,80-4,89/, Дунд /4,5 -4,7,79/, Мүү /4,50-аас доош/ үнэлгэээр дүгнэнэ. Дутуу, огт хийтээгүй ажилбар тус бүрээс хасагдах оноо /Хавсралт -4/-гоор тооцно.

Шалгасан: Комиссын гишүүд 1.....

2

3

ТҮҮГАЗРЫН захирлын 2013 оны тушаалын дөрөвдүгээр хавсралт

Өөрөө, коридорын үйлчлэгчийн заавал хийж дадсан байх ажилбарыг шалгах үзүүлэлт

A	1	2	3	4	5	6
Үйлчлэгчийн овог ,Нэр Хибс, чулуун шалыг зориулалтын машинаар угаах, цэвэрлэх, өнгөлөх	Мебель ширээ болон бусад тавилтыг угааж өнгөлөх	Цахилгаан, электрон, /компьютер, олшрууллагч, утас зэрэг/ техник хэрэгслийг угааж өнгөлөх	Дундач оноо	Нийт оноо	Шалгуулагчийн гарын үсэг	

Документация по стандарту ISO 9001

Үзүүлэлтийг Онц -А/4,9-5,0/, Сайн-В /4,80-4,89/, Дунд /4,5 -4,7,79/, Мүү /4,50-аас доош/ Үнэлгээгэр дүгнэнэ. Дутуу, огт хийгээгүй ажилбар тус бүрээс хасгахан онго /Хавсралт -3/- гоор тооцно.

Ариун цэврийн өрөөний үйлчлэгчийн заавал хийж дадсан байх ажилбарыг шалгах үзүүлэлт

ТЗ/Эгээрэн замирлын 2013 оны 25 туслаацын тавдугаар хавсралт



Огноо.....	Узүүлэлт	Хананы плита, кабин, шалыг угааж өнгөлөх	Холигч болон бусад никель тоноглолуудыг цэвэрлэж өнгөлөх	Дундач оноо	Нийт оноо	Шалгуулагчийн гарын үсэг
A	1	2	3	4	5	6

Дуттуу буруу, огт хийгдээгүй ажлын тэмдэлэгээ

Үзүүлэлтийг Онц -А/4,9-5,0/, Сайн-В /4,80-4,89/, Дунд /4,5 -4,7,79/, Мүү /4,50-аас доош/ үнэлгэээр дүгнэнэ. Дутуу, огт хийгдээгүй ажилбар тус бурээс хасагдах оноо /Хавсралт -4/- гоор тооцно.

Шалгасан: Комиссын гишүүд 1

2.....

3.....

Өрөө, коридорын үйлчлэгчийн ажлыг дүгнэх үзүүлэлтийн хасагдах оноо

д/д	Хийж гүйцэтгэх ажилбарууд	Хасагдах оноо
1	Өрөөгөө хянаагүй бол	0,1
2	Цонхны цэвэрлгээ /A.6.1/	
	Цонхны хүрээ модыг арчиж цэвэрлээгүй бол	0,2
	Цонхны хацар арчаагүй бол	0,1
	Цонхны шилийг стандартын дагуу арчаагүй бол	0,3
	Цонхны тавцанг савандаж угаагүй бол	0,3
	Салхивч нээж агаар сэлгээгүй бол /A.6.2/	0,3
3	Цэцгийн арчилгаа /A.6.3/	
	Цэцгийн сав, суурь тавгийг арчаагүй бол	0,2
	Цэцгийн тоосыг арчаагүй бол	0,2
	Цэцгийг усалж байранд нь буцааж тавиагүй бол	0,3
4	Халаах хэрэгсэлийн цэвэрлэгээ /A.6.4/	
	Халаах хэрэгслийг арчаагүй бол	0,2
	Халаах хэрэгслийн арын хэсэг, хажуугийн модолгоог арчаагүй бол	0,3
	Халаах хэрэгслийн хоолойг арчаагүй бол	0,2
5	Хивсний цэвэрлэгээ /A.6.5/	
	Хивсний зөвхөн нэг талыг соруулсан бол	0,2
	Хивсийг дутуу соруулсан бол	0,1
6	Шалны цэвэрлэгээ /A.6.6/	
	Шалны тоосыг дутуу соруулсан бол	0,1
7	Ширээний цэвэрлэгээ /A.6.7/	
	Ширээний тавцанг стандартын дагуу арчаагүй бол	0,1
	Ширээний хажуу, тавцангийн доод талыг арчаагүй бол	0,2
	Ширээн дээрх эд зүйлсийг арчиж буцаан байрлуулаагүй бол	0,3
8	Телефон, факсын аппаратын цэвэрлэгээ/A.6.8 , A.6.9/	
	Утсыг чагнаж шалгаагүй бол	0,2
	Утасны гадаргууг арчаагүй бол	0,2
	Утасны трубка,холбогч утсыг арчаагүй бол	0,3
9	Компьютер, түүний иж бүрдэл /A.6.10/	
	Компьютер арчаагүй бол	0,2
	Дэлгэцийг арчаагүй буюу стандартын дагуу арчаагүй бол	0,3
	Гар болон хулганыг арчаагүй бол	0,2
	Процессор арчаагүй бол	0,2
	Хулгана арчаагүй бол	0,1
10	Телевизорын цэвэрлэгээ /A.6.11/	
	Телевизорыг арчаагүй бол	0,2
	Дэлгэцийг стандартын дагуу арчаагүй бол	0,3
	Холбогч утсыг арчаагүй бол	0,2

11	Бүйдан, сандлын цэвэрлэгээ /A.6.12/	
	Бүйданг арчаагүй бол	0,2
	Сандлыг нэг бүрчлэн арчаагүй бол	0,2
	Сандлын хөлийг арчаагүй бол	0,1
12	Сейфны цэвэрлэгээ /A.6.13/	
	Сейфны цэвэрлгээг хийгээгүй бол	0,2
13	Шкаф, номын тавиурын цэвэрлэгээ /A.6.14/	
	Шкаф, номын тавиурын гадна талыг арчаагүй бол	0,2
	Шкафны дотор хэсгийг арчаагүй бол	0,2
	Шилийг арчаагүй бол	0,1
14	Толь, өлгүүрийн цэвэрлэгээ /A.6.15, A.6.16/	
	Тольны хурээг арчаагүй бол	0,1
	Тольны шилдийг стандартын дагуу арчаагүй бол	0,2
	Өлгүүрийг арчаагүй бол	0,2
15	Хананы зураг, бусад эд зүйлс/A.6.17/	
	Хананы зураг бусад эд зүйлсийг огт арчаагүй бол	0,3
	Арчаагүй орхигдуулсан эд зүйл тус бүрээр	0,1
16	Шал, шалны хүрээ /A.6.18/	
	Шалыг савандаж угаагаагүй бол	0,2
	Шалны хүрээг савандаж угаагаагүй бол	0,2
17	Хогийн савны цэвэрлэгээ /A.6.19/	
	Хогийг авч дотор савыг угаагүй бол	0,2
	Зөвхөн гадна савыг угааж арчсан бол	0,2
18	Хаалганы цэвэрлэгээ /A.6.20/	
	Хаалгыг арчаагүй бол	0,2
	Хаалганы нэг талыг арчаагүй бол	0,1
19	Салхивч /A.6.21/	
	Салхивч хаагаагүй бол	0,1
	Хөшиг, тюлийг тэгшлээгүй бол	0,1
20	Унтраалганы цэвэрлэгээ /A.6.22/	
	Ажлаа хянаж,унтраалга арчаагүй бол	0,2
	Өрөөний гэрлийг унтраагаагүй бол	0,2
21	Хаалганы баруулын цэвэрлэгээ /A.6.23/	
	Хаалганы бариулыг арчаагүй бол	0,2
	Ажилбаруудаас дутуу хийсэн, мартсан бол	0,3
	Дутуу хийсэн ажилбарыг санаж нөхөн гүйцэтгэсэн бол	0,1

Ариун цэврийн өрөөний үйлчлэгчийн ажлыг дүгнэх үзүүлэлтийн хасагдах оноо

д/д	Хийж гүйцэтгэх ажилбарууд	Хасагдах оноо
1	Өрөөгөө хянаагүй бол	0,1
2	Цонхны цэвэрлэгээ /A.7.1/	
	Цонхны хүрээ модыг арчиж цэвэрлээгүй бол	0,2
	Цонхны хацар арчаагүй бол	0,1
	Цонхны шилийг стандартын дагуу арчаагүй бол	0,3
	Цонхны тавцанг савандаж угаагүй бол	0,3
	Салхивч нээж агаар сэлгээгүй бол /A.7.2/	0,3
3	Халаах хэрэгслийн цэвэрлэгээ /A.7.3/	
	Халаах хэрэгслийг арчаагүй бол	0,2
	Халаах хэрэгслийн арын хэсэг, хажуугийн модолгоог арчаагүй бол	0,3
	Халаах хэрэгслийн хоолойг арчаагүй бол	0,2
4	Суултуурын цэвэрлэгээ /A.7.4 /	
	Суултуурыг зориулалтын бодисоор цэвэрлээгүй бол	0,2
	Угаалгын нунтагтай усаар угаагүй бол	0,1
	Суултуурын тагны чихийг сойзджүүлж угаагаагүй бол	0,2
5	Писаурын цэвэрлэгээ /A.7.5/	
	Писаурыг халуун, хүйтэн усаар булхаагүй бол /5-6 удаа/	0,3
	Угаалгын нунтагтай усаар угаагүй бол	0,2
	Цэвэр алчуураар өнгөлөөгүй бол	0,1
6	Угаалтуурын цэвэрлэгээ /A.7.6/	
	Угаалтуурурыг зориулалтын бодисоор сойзджүүлж угаагаагүй бол	0,3
	Угаалгын нунтагтай усаар угаагаагүй бол	0,2
	Цэвэр усаар зайлж хуурай алчуураар өнгөлөөгүй бол	0,1
7	Тольны цэвэрлэгээ /A.7.7/	
	Тольны хүрээг арчаагүй бол	0,1
	Толийг шил толь өнгөлөгчөөр өнгөлж хуурай алчуураар арчаагүй бол	0,2
	Утасны трубка, холбогч утсыг арчаагүй бол	0,3
8	Цаас тогтоогч, холигч, хаалганы бариулын цэвэрлэгээ/A.7.8/	
	Цаас тогтоогчийг угааж өнгөлөөгүй бол	0,2
	Крантыг угааж өнгөлөөгүй бол	0,2
	Хаалганы бариулыг угааж арчаагүй бол	0,2
9	Хананы цэвэрлэгээ /A.7.9/	
	Ханыг чийгтэй алчуураар арчаагүй бол	0,2
	Хуурай алчуураар өнгөлөөгүй бол	0,2
	Ханыг чийгтэй алчуураар арчаагүй бол	0,1
10	Кабины хаалганы цэвэрлэгээ /A.7.10/	
	Савантай усаар угаалгүй зөвхөн чийгтэй алчуураар арчсан бол	0,2

	Хаалганы бариулыг арчаагүй бол	0,1
	Хлораминтай усаар ариутгаагүй бол	0,1
11	Хогийн савны цэвэрлэгээ /A.7.11/	
	Хогийг аваагүй бол	0,2
	Хогийн савны зөвхөн гадна талыг угаасан бол	0,1
	Хогийн савны зөвхөн дотор талыг угаасан бол	0,1
	Хогийн уутыг шинэчилж тавиагүй бол	0,2
12	Шал, шалны хүрээ /A.7.13/	
	Шалыг савандаж угаагаагүй бол	0,2
	Шалны хүрээг савандаж угаагаагүй бол	0,2
13	Хаалганы цэвэрлэгээ /A7.14/	
	Хаалгыг арчаагүй бол	0,1
	Хаалганы нэг талыг арчаагүй бол	0,2
	Хаалганы нэг талыг арчаагүй бол	0,2
14	Бусад цэвэрлэгээ, үйлчилгээ/A.7.15-19/	
	Писаурт үнэр дарагчийг байрлуулаагүй бол	0,1
	Хүж асаах буюу агааржуулагч цацаагүй бол	0,1
	Цаас тогтоогчид цаасыг байрлуулаагүй бол	0,2
	Тавиур дээр саван байрлуулаагүй буюу шингэн саванг цэнэглээгүй бол	0,2
	Ажлын үр дүнг хянаагүй бол	0,2
	Ажилбаруудаас дутуу хийсэн, мартсан бол	0,3
	Дутуу хийсэн ажилбарыг санаж нөхөн гүйцэтгэсэн бол	0,1